



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРТЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/290

Мөрөн сум

Авто замын ажлыг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл

ийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.5, 28 дугаар зүйлийн 28.1, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвийн 1,62 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Н.Буян-Өлзий (Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч)

Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

Э.Наранчимэг (Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн хяналтын инженер)

Ц.Оюун-Эрдэнэ (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Ч.Намшир ("Ти Ай Би" ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Б.Баянбилэг ("Хүслэнт Бүтээмж" ХХК-ийн Захирал)

Д.Бат-Эрдэнэ ("Хүслэнт Бүтээмж" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг даргын албан үүргийг түр гүйцэтгэгч)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын Архитектор, дэд бүтэц, нийтийн дээвэр хариуцсан мэргэжилтэн)

Д.Билгүүн (Хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн Зам хариуцсан ажилтан)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Авто зам засварын ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Авто зам засварын ажлыг ашиглалтад оруулсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй зам засварын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН